



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/44

Төмөрбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас “Шинэ хоршоо” хөдөлгөөний талаар малчин өрхүүдэд таниулан сурталчлах, мэдээлэл өгөх, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодыг идэвхжүүлэх, чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Энхбаяр- (Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Г.Нямханд- (Засаг даргын Тамгын газрын дарга)

Ц.Бямбадорж- (ИТХ-ын нарийн бичгийн дарга)

Ц.Баярцэнгэл- (Хэсгийн төлөөлөгч)

Ц.Доржготов- (Жаргалант, 1-р багийн Засаг дарга)

Н.Бямбачулуун- (Нарийн, 2-р багийн Засаг дарга)

Л.Батсайхан- (Тариат, 3-р багийн Засаг дарга)

Д.Эрдэнэжаргал- (Тээл, 4-р багийн Засаг дарга)

Ш.Нацагдорж – (Сумын төв, 5-р багийн Засаг дарга)

Д.Пүрэвдорж- (Улсын бүртгэгч)

Д.Мөнхзул- (ХААН банкны салбарын эдийн засагч)

Э.Хадбаатар- (Төрийн банкны салбарын захирал)

П.Ганчимэг- (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Б.Ёндонсамбуу- (Татварын байцаагч)

Э.Мөнгөнзагас- (Мал эмнэлгийн тархвар зүйч)

Д.Сайнбаяр- (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга Ж.Нямханд- (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

2. “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг 14 хоног тутам танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ч.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Нямханд)-д даалгасугай.

ДАРГА

А.МӨНХ-ЭРДЭНЭ